



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/231

Арвайхээр


**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ–2020” хөтөлбөрийн 3.3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Швед улсад зохион байгуулагдах “Пауэрлифтингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн”-д оролцох Өвөрхангай аймгийн тамирчин Сугарын Богд-Очирт 1.200.000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах 1.200.000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100511